



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/036/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn Аудитор: Л.Отгон Утас: 99059489 Цахим хаяг: devjikhcapital.audit@gmail.com</p>
---------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	233,788.96	298,094.42
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,566,463.78	1,669,015.11
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,800,252.74</b>	<b>1,967,109.53</b>
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,800,252.74	1,966,790.78
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,800,252.74</b>	<b>1,967,109.53</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,078,416.14	1,437,399.87
	Үйл ажиллагааны зардлын дүн	849,329.04	1,270,861.83
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>229,087.09</b>	<b>166,538.04</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	(30,500.00)	0.00
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>198,587.09</b>	<b>166,538.04</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,601,665.65	1,800,252.74
	Тайлант оны үр дүн	198,587.09	166,538.04
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>1,800,252.74</b>	<b>1,966,790.78</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	758,154.39	1,070,399.56
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	714,203.73	1,052,649.56
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>43,950.65</b>	<b>17,750.00</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(43,950.65)</b>	<b>(17,750.00)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>		
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>581,489.35</b>	<b>933,607.30</b>
	Урсгал зардал	581,489.35	933,607.30
	Хөрөнгийн зардал		
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>605,812.56</b>	<b>878,630.90</b>
	Улсын төсвөөс санхүүжих		
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	586,065.90	864,729.00
	Туслах үйл ажиллагааны орлого	19,746.66	13,901.90

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 169,017.4 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**
- Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг 1,004.3 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээ, үр дүнгийн тайланд тусад нь тайлагнаагүй.
- Нэмэлт санхүүжилтийн төсвийн хэлбэлзэл 56,822.4 мянган төгрөгөөр зөрүүтэй.
- Мөнгөн гүйлгээний тайланд 17,750.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг биет ба бус хөрөнгө худалдан авснаар тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн.
- Хандивын хөрөнгөөр ирсэн 44,440.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 40,000.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг бүртгэлд, 9,000.0 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэлд тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн.

Залруулагдаагүй нийт 131,305.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 131,305.3 мянган төгрөгийн 7 зөрчил<sup>2</sup> илэрч 682.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 130,622.9 мянган төгрөгийн 6 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

### Төлбөрийн акт

1. Ажиллагсад үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 682.4 мянган төгрөгийг илүү олгосон нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох"; 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 16.5.9-т "дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

### Албан шаардлага

1. Нягтлан бодогчийн цалингийн нэмэгдлийг 1,588.7 мянган төгрөгөөр давхардуулан тогтоож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн орон тооны нягтлан бодогч ажиллуулах албан шаардлага хүргүүлсэн.

2. Цахим дэлгүүрээс 15,960.0 мянган төгрөгийн компьютер, тавилга худалдан аваагүй, хувь хүнээс худалдан авалт хийсэн байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрээс худалдан авалт хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Засаг даргын нөөц хөрөнгөөс спортын болон нийтээр тэмдэглэх баярын арга хэмжээний зардалд /бөхийн бай шагнал, золголт, бэлэг дурсгалын зүйл / 8,911.2 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

4. Орон нутгийн төсвөөс 100 жилийн ойн дэмжлэгт олгосон санхүүжилтээс 97,956.0 мянган төгрөгийг урлагийн тоглолт, сав баглаа боодол, тэмдэг, бэлэг дурсгалын зүйл, дайллага цайллага зэргийг худалдан авах зэргээр зарцуулсан нь ТХТХ зөрчиж үр ашиггүй зарцуулалт болсон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Төсвийн хөрөнгийг бэлэг дурсгалын зүйл, хуульд заагаагүй шагнал урамшуулалд зарцуулж буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

5. Жолоочийн тооцооны замын хуудсаар албаны бус хэрэгцэээнд /ойн арга хэмжээ 6,207.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Төсвийн хөрөнгийг батлагдсан төсвийн дагуу албан бус хэрэгцээнд зарцуулахгүй байх шаардлага хүргүүлсэн

6 Шилэн дансны цахим системд 1,157.8 мянган төгрөгийн 31 мэдээллийг ил тод байршуулахаас 357.2 мянган төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 128,999.7 мянган төгрөгийн 14 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;", 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;", 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна

Шийдвэрлэлт: Шилэн дансны цахим системд мэдээлэл бүрэн оруулах албан шаардлага хүргүүлсэн

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төгрөг сумын Засаг даргын Тамгын газар	4	169,017.4			4	169,017.4	4	169,017.4				
Дүн	4	169,017.4			4	169,017.4	4	169,017.4				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төгрөг сумын Засаг даргын Тамгын газар	6	131,305.3	1	682.4	5	130,622.9			-	-	-	-
Дүн	6	131,305.3	1	682.4	5	130,622.9			-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн	22	-	-	-	-	-	22	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-
-Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	<b>НИЙТ</b>		<b>1</b>				<b>1</b>		

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Төгрөг сумын Засаг даргын Тамгын газар	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг 1,004.3 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээ, үр дүнгийн тайланд тусад нь тайлагнаагүй.	1	1,004.3	-	-	-	-	1	1,004.3	-	-	-	-
	Нэмэлт санхүүжилтийн төсвийн хэлбэлзэл 56,822.4 мянган төгрөгөөр зөрүүтэй.	1	56,822.4	-	-	-	-	1	56,822.4	-	-	-	-
	Мөнгөн гүйлгээний тайланд 17,750.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг биет ба бус хөрөнгө худалдан авснаар тайлагнаагүй байна.	1	17,750.0	-	-	-	-	1	17,750.0	-	-	-	-
	Хандивын хөрөнгөөр ирсэн 44,440.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 40,000.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг бүртгэлд тайлагнаагүй байна.	1	84,440.8	-	-	-	-	1	84,440.8	-	-	-	-
	Хандивын хөрөнгөөр ирсэн 9,000.0 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэлд тайлагнаагүй байна.	1	9,000.0	-	-	-	-	1	9,000.0	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>5</b>	<b>169,017.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>169,017.4</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>